# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр Дугаар 235 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өмнөговь аймгийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 97-15 ӨМҮ улсын дугаар, JN1TCSY61Z0581042 арлын дугаартай, Ниссан патрол маркийн тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, засаж сэлбэн ашиглах зорилгоор Сүхбаатар аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Өмнөговь аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Б.Батжаргал, Сүхбаатар аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга Р.Алтаннар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын Мөнххаан сум дахь Сум дундын цагдаагийн тасаг)-д эзэмшүүлэх, засан сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийг бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13?000820

10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны...05...дугаар сарын ...01...ны/ний өдрийн
.........235.........дугаар тогтоолын хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ДАНСНААС ХАСЧ, СҮХБААТАР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины нэр, төрөл | Явсан км-ийн заалт | Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо | Арлын дугаар | Улсын дугаар | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ниссан Патрол суудлын автомашин | 111,458.00 | 2011 | JN1TCSY61Z0581042 | 97-15 ӨМҮ | 22,000,000.00 |
| НИЙТ ДҮН | | | | | | 22,000,000.00 (хорин хоёр сая) |